

INDEPENDENT DIRECTOR REPORT OF XACBANK

By: Niraj Vedwa

Quarter 4, 2022



STATEMENT

I, Niraj Vedwa, the Independent Director at the Board of Directors of XacBank, have prepared this Independent Director's Report (the "Report") pursuant to: (i) the Company Law and the Banking Law; (ii) banking regulations issued by the Bank of Mongolia ("BoM") – Procedures on Good Governance Review of Banks (the "Good Governance Review"), and Regulation on Nomination, Appointment, and Resignation of Independent Directors of Banks (the "INED Regulation"); (iii) XacBank's Charter and other governance policies applicable.

The Report covers the period of Quarter IV 2022. (the "Applicable Period").

1. ATTENDANCE REPORT

(INED Regulation Clauses 5.2.1 and 5.2.2)

The following meetings as shown in Schedule 1 have been convened and held in the Applicable Period.

Board meetings in the Applicable Period

Schedule 1

| Meetings | Attendance | Date |
|--|----------------------------|-------------|
| Board meeting | As an independent director | 1 Dec 2022 |
| Board Audit Committee meeting | As a member | 1 Dec 2022 |
| Board Risk Management Committee meeting | As a member | 1 Dec 2022 |
| Board Governance, Nomination, Compensation Committee meeting | As an observer | 1 Dec 2022 |
| Extraordinary Shareholders' meeting | As an independent director | 21 Oct 2022 |

Board meeting[s]

The board regular meeting was held on [1 Dec 2022] and the relevant agenda items were:

1. Reports of the Board Committees (GNCC, BRMC, BAC)
2. Management Report
3. Budget 2023
4. CEO KPIs
5. IPO and restructuring update
6. IT and Digital Banking update
7. Succession planning

Reviewed the updates in BRMC and BAC meetings and voted in favor of all the resolutions. There was no disagreement on any agenda item. In Board meetings, voted in favor of all the resolutions of the 3 committees. There were no disagreements. Have provided suggestions on the Core Banking and Digital Banking Platforms and transformations from the IT perspective so that XacBank can gain Digital competitiveness.

Furthermore, I have attended the following online voting meetings as shown in Schedule 2.

| Online Voting meetings in the Applicable Period | | Schedule2 |
|---|--|----------------|
| Meetings | Voting item | Date |
| Board online voting meeting | Approval of the Compliance Program of XacBank | 17-18 Oct 2022 |
| Board online voting meeting | Appointment of Erik Versavel on the Board Audit and Board Risk Management Committees | 14 Nov 2022 |
| Board online voting meeting | Approval of conflict of interest transaction/sale of OREO asset | 10-17 Nov 2022 |
| Board online voting meeting | Approval of conflict of interest transaction | 9-16 Dec 2022 |
| Board online voting meeting | Amendment to the approval of the One-Off Incentive Grant | 19-26 Dec 2022 |
| Board Audit Committee online voting meeting | External audit plan – year end 2022 | 8-28 Nov 2022 |
| Board Risk Management Committee online voting meeting | none | |

All above meetings had detailed discussions around the agenda items and post pre-reading / listening to the management stakeholders, I approved the resolutions pertaining to Compliance Program / Appointment of Erik Versavel to BAC and BRMC / Conflict of Interest Transactions/ One off Incentive Grant and External Audit Plan. There were no disagreements.

2. CONFLICT OF INTEREST TRANSACTION AND SIGNIFICANT AMOUNT TRANSACTION REPORT

(Banking law Clause 33.5 and INED Regulation Clause 5.2.3)

Pursuant to Clause 33.5 of the Banking Law, independent directors must vote on the conflict of interest transactions.

In the quarter, there have been 2 conflict of interest transactions approved by the Board and I casted my votes on both these transactions.

- An OREO Purchase request which fell under the Related Party Conflict of Interest as per Section 89.1 and 89.2 of Company Law.
- Credit exposure limit increase by one of Bank's top clients who also have investment by a shareholder of Bank and falls under the Related Party Transaction.

After Discussions and understanding management note and recommendation, I voted in favor of approving both these transactions.

I note that, in cases where any of the directors had conflict of interest, such director revealed their conflict of interest at the beginning of the meeting and did not vote on the matter.

3. GOVERNANCE REPORT

(Company Law Clause 79.3, INED Regulation Clause 5.2.4, and Good Governance review Clause 3.5)

The above-mentioned clauses of respective laws and regulations provide for independent directors the authority in the oversight over the Board and the executive management if their acts and decisions are in the best interest of the bank and in line with the regulatory requirements for the benefit of the Bank's stakeholders, including but not limit to, shareholders, customers, depositors and employees.

My observation is that XacBank has set highest standards of Governance with very good processes and review mechanism. There is approval matrix clearly defined at various levels including taking Board approval for exceptional items.

| Actions taken under the Company Law Clause 79.3 and Good Governance Review Clause 3.5 | |
|---|--|
| Company Law Clause 79.3.1 and Good Governance Review Clause 3.5.5 (BANK'S COMPLIANCE WITH LAWS AND REGULATIONS) | Bank has very Good Governance and complies with Laws and Regulations as set by authorities in Mongolia. There was no reported breach or compliance issue reported. |
| Company Law Clause 79.3.2 (BANK'S TRANSPARENCY) | Bank is transparent in sharing of information with shareholders, customers and employees as per guidelines. |
| Company Law Clause 79.3.3 (PROVISION OF INFORMATION TO THE SHAREHOLDERS) | I have attended the Extraordinary Shareholders' meeting held on 21 st October and made myself available to any questions from the shareholders at the meeting. There were no questions raised to me by any Shareholder. |
| Good Governance Review Clause 3.5.1 (ENSURING THE DECISIONS MADE BY THE BOARD AND THE MANAGEMENT IS IN THE BEST INTEREST OF THE BANK) | As I am a member of BAC and BRMC and sit as an Observer in GNCC committees, I read all the pre-reading documents and raise points where necessary. Bank follows very good Governance and decisions are taken by Management as per documented procedures and important decision points are also placed at Board level for review and approval. At the beginning of every quarter Board meetings, there is always an update on the implementation of previous quarter decisions. |
| Good Governance Review Clause 3.5.2 | During the quarter, there was no issue with respect to Board and Management Compliance to Law |

| | |
|---|--|
| (THE BOARD AND THE MANAGEMENT COMPLIANCE WITH LAWS) | |
| Good Governance Review Clause 3.5.3 (PROTECTION OF CUSTOMERS AND DEPOSITORS) | During the quarter, there was no reported issue with regard to Protection of Customers and Depositors. |
| Good Governance Review Clause 3.5.6 (REPORTING OF VIOLATIONS TO BOM) | During the quarter, there was no reported violation and hence I have not reported any aberration or violation to BOM |


4. OTHER

As I had travelled to UB for the Board meetings, I scheduled external visits along with a few Board Directors.

- Visited a SME factory in Meat processing business in UB Suburb. Met with the Owner and his team and understood how he launched and scaled his business with Loan from XacBank
- Visited a [REDACTED] Diagnostic Centre and met with the Owner. Understood how she started her business and grew the team to almost 30 staff with Loan Funding from XacBank.
- Interacted with Management Team members over the official dinner and understood how they were all so committed to take bank to higher levels.

The commitment shown by bank management team is very positive and exemplary.

I place my ID Report for Q4 on record.



Niraj Vedwa

ХАСБАНКНЫ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНИЙ ТАЙЛАН

Нираж Вэдва

2022 оны 4 дүгээр улирал



МЭДЭГДЭЛ

ХасБанкны Төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ”)-ийн Хараат бус гишүүн Нираж Вэдва миний бие: (i) Компанийн тухай хууль (“КтХ”), Банкны тухай хууль (“БтХ”); (ii) Монголбанкны холбогдох журмууд болох “Банкны зохистой засаглалын зарчмын хэрэгжилтийн хяналт шалгалтын журам” (“Засаглалын хяналт шалгалтын журам”), “Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн Хараат бус гишүүнийг нэр дэвшиүүлэх, томилох, чөлөөлөх журам” (“Хараат бус гишүүний журам”); (iii) ХасБанкны Дүрэм болон бусад холбогдох засаглалын бодлого, зарчмын дагуу энэхүү Хараат бус гишүүний тайлан (“Тайлан”)-г бэлтгэсэн болно.

Тайлан нь дараах хугацааг хамарна: [2022 оны 4 дүгээр улирал] (“Тайлант хугацаа”).

1. ОРОЛЦООНЫ ТАЙЛАГНАЛ

(Хараат бус гишүүний журмын 5 дугаар зүйлийн 5.2.1 болон 5.2.2 дахь заалт)

Тайлант хугацаанд Хүснэгт 1-д заасан дараах хурлуудад оролцож ажиллалаа.

Хамрах хугацаан дахь ТУЗ-ийн хурлууд

Хүснэгт 1

| Хурлууд | Оролцсон байдал | Огноо |
|--|-------------------------------------|--------------------------|
| ТУЗ-ийн ээлжит хурал | Хараат бус гишүүнээр | 2022/12/01 |
| ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо (АХ)-ны хурал | Гишүүнээр | 2022/12/01 |
| ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороо (ЭУХ)-ны хурал | Гишүүнээр | 2022/12/01 |
| ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшиүүлэх цалин урамшууллын хороо (ЗНДЦУХ)-ны хурал Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал | Ажиглагчаар Хараат бус гишүүнээр | 2022/12/01 2022/10/21 |

ТУЗ-ийн хурал [хурлууд]

ТУЗ-ийн 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэж, хуралдав. Үүнд:

1. ТУЗ-ийн дэргэдэх Хороодын тайлан (ЗНДЦУХ, ЭУХ болон АХ);
2. Удирдлагын тайлан;
3. 2023 оны төсөв;
4. Гүйцэтгэх захирлын 2023 оны КРІ
5. IPO болон бүтцийн өөрчлөлт;
6. Мэдээлэл технологи болон цахим банктай холбоотой шинэ мэдээлэл;
7. Залгамж халааны төлөвлөгөө.

ТУЗ-ийн дэргэдэх ЗНДЦУХ болон ЭУХ-ны саналыг хэлэлцэж, түүнээс гарсан бүх шийдвэрүүд дээр санал хураалт явуулсан. Хэлэлцсэн асуудлуутай холбоотойгоор ямар нэгэн зарчмын зөрүүтэй тайлбар, санал байгаагүй. ТУЗ-ийн хурлаар 3 хорооноос гаргасан бүх шийдвэрүүд дээр санал хураалт явуулсан бөгөөд зарчмын зөрүүтэй тайлбар, санал байгаагүй. Харин ХасБанкны цахим өрсөлдөх чадварыг сайжруулахын тулд Үндсэн банк болон цахим банкны платформууд, шилжилт дээр мэдээллийн технологийн өөрчлөлтуүдийг ашиглах саналыг гаргасан.

Мөн түүнчлэн Хүснэгт 2-т тусгасан дараах цахим санал хураалтын хурлуудад оролцсон.

Хамрах хугацаан дахь цахим санал хураалтын хурлууд

Хүснэгт 2

| Хурлууд | Санал хураалт | Огноо |
|---|--|------------------|
| ТУЗ-ийн цахим санал хураалтын хурал | Банкны хянан нийцүүлэлтийн хөтөлбөр батлах | 2022/10/17-10/18 |
| ТУЗ-ийн цахим санал хураалтын хурал | Эрик Версавелийг ТУЗ-ийн дэргэдэх Аудитын Хороо болон Эрсдэлийн Удирдлагын Хороонийн гишүүнээр томилох | 2022/11/14 |
| ТУЗ-ийн цахим санал хураалтын хурал | Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгийг худалдах сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлах | 2022/11/10-11/17 |
| ТУЗ-ийн цахим санал хураалтын хурал | Сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлах | 2022/12/09-12/16 |
| ТУЗ-ийн цахим санал хураалтын хурал | 1 удаагийн урамшуулал олгох тухай тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах | 2022/12/19-12/26 |
| ТУЗ-ийн дэргэдэх АХ-ны цахим санал хураалтын хурал | Хөндлөнгийн аудитын төлөвлөгөө - 2022 оны жилийн эцсийн байдлаар | 2022/11/08-11/28 |
| ТУЗ-ийн дэргэдэх ЭУХ-ны цахим санал хураалтын хурал | байхгүй | |

Дээрх хурлуудаар хэлэлцэх асуудлуудыг дэлгэрэнгүй хэлэлцсэн хурлын материалтай урьдчилан танилцаж, удирдлагын багийн гишүүдийг сонссони дараа i. Банкны хянан нийцүүлэлтийн хөтөлбөр, ii. Эрик Версавелийг ТУЗ-ийн дэргэдэх АХ болон ЭУХ-ны гишүүнээр томилох, iii. Сонирхлын зөрчилтэй хэлцлүүд, iv. 1 удаагийн урамшуулал олгох болон Хөндлөнгийн аудитын төлөвлөгөөг батлах тухай ТУЗ-ийн тогтоолуудыг дэмжсэн санал өгсөн. Зарчмын зөрүүтэй тайлбар, санал байгаагүй.

2. СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ БА ИХ ХЭМЖЭЭНИЙ ХЭЛЦЛИЙН ТАЙЛАН

(БтХ-ийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг болон Хараат бус гишүүний журмын 5 дугаар зүйлийн 5.2.3 дахь заалт)

БтХ-ийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэгт Банкны ТУЗ-ийн Хараат бус гишүүн нь сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлахад заавал оролцож, санал өгнө гэж заасан.

Тайлангийн хамрах хугацаанд ТУЗ-өөс хоёр сонирхлын зөрчилтэй хэлцлийг баталсан ба тус бүрт саналаа өгч ажилласан. Үүнд:

i. КтХ-ийн 89 дүгээр зүйлийн 89.1, 89.2-т заасны дагуу өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгийг худалдах Холбогдох этгээдийн сонирхлын зөрчилтэй хэлцэл;

ii. Банкны хувьцаа эзэмшигчийн хувьцааг нь эзэмшдэг Банкны топ харилцагчид олгох зээлийн хэмжээг нэмэгдүүлэх сонирхлын зөрчилтэй хэлцэл.

Хэлэлцүүлэг өрнөж, удирдлагын тайлбар, зөвлөмжийг сонссони дараа тус хоёр сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлахыг дэмжсэн.

ТУЗ-ийн гишүүд тухайн асуудлаар ашиг сонирхлын зөрчилтэй байсан тохиолдолд хурлын эхэнд сонирхлын зөрчилтэй болохоо илэрхийлж, тухайн асуудлаар санал өгөөгүй болохыг дурдах нь зүйтэй.

3. ЗАСАГЛАЛЫН ТАЙЛАН

(КтХ-ийн 79 дүгээр зүйлийн 79.3 дахь хэсэг, Хараат бус гишүүний журмын 5 дугаар зүйлийн 5.2.4 дахь заалт болон Засаглалын хяналт шалгалтын журмын 3 дугаар зүйлийн 3.5 дахь хэсэг)

Дээр дурдсан хууль тогтоомжоор Хараат бус гишүүн нь Банкны оролцогч талууд, түүний дотор Хувьцаа эзэмшигч, харилцагч, хадгаламж эзэмшигч болон банкны ажилтны эрх ашгийг хамгаалах үүднээс ТУЗ, Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа, гаргасан бодлого, шийдвэр нь Банкны эрх ашиг, сонирхолд нийцсэн эсэх, мөн үйл ажиллагаа нь хууль тогтоомж дүрэм журамд нийцсэн эсэхэд хяналт тавих эрхтэй.

Миний ажигласнаар банкны засаглалыг дүгнэхэд, ХасБанк нь маш сайн үйл ажиллагаа, хяналт тавих механизмаар компанийн засаглалын өндөр стандартыг тогтоосон. Онцгой тохиолдолд ТУЗ-ийн зөвшөөрлийг авах шаардлагатай гэх зэргээр бүхий л түвшинд зөвшөөрөл авах матрицыг тодорхой болгосон.

КтХ-ийн 79 дүгээр зүйлийн 79.3 дахь хэсэг, Засаглалын хяналт шалгалтын журмын 3.5 дахь хэсэгт заасан арга хэмжээ

| | |
|--|---|
| КтХ 79.3.1 болон Засаглалын хяналт шалгалтын журмын 3.5.5 (БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХУУЛЬ ТОГТООМЖ, ДҮРЭМ, ЖУРМЫН НИЙЦЭЛ) | ХасБанк маш сайн засаглалтай бөгөөд үйл ажиллагаандаа эрх бүхий этгээдийн баталсан хууль тогтоомжийн нийцлийг хангаж ажилладаг. Зөрчлийн асуудал, эсхүл тайлрагнагдсан асуудлаар дагаж мөрдөх зүйл байгаагүй. |
| КтХ 79.3.2 (БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ) | ХасБанк удирдамжийн дагуу хувьцаа эзэмшигч, харилцагч, ажилтнуудад банкны үйл ажиллагааны мэдээллийг өгч, ил тод байдлыг хангаж ажилладаг. |
| КтХ 79.3.3 (ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙГ МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАХ) | Миний бие 2022 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцсон ба тухайн хурлын үеэр хувьцаа эзэмшигчдээс асуух асуултад хариулах, тодруулга хийхэд бэлэн байсан. Хувьцаа эзэмшигчид аливаа асуулт асуугаагүй. |
| Засаглалын хяналт шалгалтын журмын 3.5.1 (ТУЗ, ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН ГАРГАСАН ШИЙДВЭР БАНКНЫ ЭРХ АШИГТ НИЙЦСЭН БАЙХ) | Миний бие ТУЗ-ийн дэргэдэх АХ, ЭУХ-ны гишүүнээр, ЗНДЦУХ-ны ажиглагчийн хувьд, хурлын бүх материалтай урьдчилан танилцаж, шаардлагатай тохиолдолд санал дэвшиүүлдэг. Банк нь компанийн сайн засаглалыг хэрэгжүүлж, удирлагын зүгээс батлагдсан журмын дагуу шийдвэр гаргадаг бөгөөд чухал асуудлыг ТУЗ-ийн түвшинд хянуулж, батлуулдаг. ТУЗ-ийн улирал бүрийн эхний хурал дээр өмнөх улирлын ТУЗ-ийн Тогтоолуудын хэрэгжилтийн талаар мэдээлдэг. |

| | |
|--|---|
| Засаглалын хяналт шалгалтын журмын 3.5.2 (ТУЗ, ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА НЬ ХУУЛЬ ТОГТООМЖИД НИЙЦСЭН БАЙХ) | Тайлан хамрах хугацаанд ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа хууль тогтоомжийн нийцээгүй талаар ямар нэгэн зөрчил гараагүй. |
| Засаглалын хяналт шалгалтын журмын 3.5.3 (БАНКНЫ ХАРИЛЦАГЧ, ХАДГАЛАМЖ ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ АШГИЙГ ХАМГААЛАХ) | Тайлан хамрах хугацаанд банкны харилцагч, хадгаламж эзэмшигчийн эрх ашгийг хамгаалахтай холбоотой ямар нэгэн асуудал гараагүй. |
| Засаглалын хяналт шалгалтын журмын 3.5.6 (МОНГОЛБАНКИНД ЗӨРЧИЛ МЭДЭЭЛЛЭХ) | Тайлан хамрах хугацаанд ямар нэгэн зөрчил гараагүй тул Монголбанкинд мэдээлсэн зөрчил байхгүй. |

4. БУСАД

Би Банкны ТУЗ-ийн хуралд оролцохоор Улаанбаатарт очих үедээ ТУЗ-ийн зарим гишүүдийн хамт дараах уулзалтуудад оролцсон. Үүнд:

- Улаанбаатар хотын захад мах боловсруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ЖДҮ (жижиг дунд үйлдвэрлэл)-тэй танилцсан. Үйлдвэрийн эзэн болон түүний багтай уулзаж, ХасБанкны зээлээр бизнесээ хэрхэн эхлүүлж, өргөжүүлсэн талаар ярилцав.
- “***” Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний төвд зочилж, эзэнтэй нь уулзалт хийсэн. ХасБанкны санхүүжүүлсэн зээлээр бизнесээ хэрхэн эхлүүлж, одоо 30 гаруй ажилтантай болж өргөжсөн талаар ярилцав.
- Банкны удирдлагын багийн гишүүдтэй уулзалт хийсэн бөгөөд банкийг илүү өндөр түвшинд хүргэхээр зорьж ажиллаж байгаа талаар ярилцсан.

Банкны удирдлагын багийн гаргасан зорилго, зорилт маш эерэг бөгөөд үлгэр жишээ байсан.

Үүгээр 4 дүгээр улирлын хараат бус гишүүний тайлангаа хүргүүлж байна.

Нираж Вэдва
ХасБанкны ТУЗ-ийн Хараат бус гишүүн